

АХБ-НЫ ШИНЭ ЕРӨНХИЙЛӨГЧ АЗИ ДАХЬ ЯДУУРАЛТАЙ ТЭМЦЭХЭЭ АМЛАВ

Манила, Филиппин (2005.2.01) Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны найм дахь Ерөнхийлөгч Харухико Курода ажлаа албан ёсоор хүлээн авч өнөөдрөөс тус банкийг удирдах боллоо. Тэрээр ажлаа хүлээн авмагцаа дэлхийн хамгийн эрч хүчтэй, хөдөлгөөнтэй бүс нутагт үйл ажиллагаа явуулахад тэнцэхүйц банк болгож АХБ-ийг өөрчлөхийг уриалав.

2000 гаруй ажилтнууддаа хандаж хэлсэн үгэндээ ноён Курода "Ази, номхон далайн бүс нутаг богино хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтөд хүрч ядуурлыг бууруулах гайхалтай их нөөц бололцоотой. Энэ нь тус бүс нутгийн хүмүүсийн өндөр чадавхитай холбоотой талаар цохон дурьдав.

Ажлын анхны өдрөө тэрээр үр ашигтай хөгжлийн тусламж үзүүлэхийн тулд бүс нутгийн улс орнуудтай нягт хамтран ажилладаг энэ банкны эрхэм зорилгыг тодорхойлохдоо "Ази Номхон далайн бүс нутаг ихээхэн хурдацтай өөрчлөгдөж байгаа өнөө үед түүний өрхийн эмч нь болсон АХБ үүнд зохицон бүс нутгийн хэрэгцээ шаардлагыг уян хатан, цаг хугацаанд нь хангадаг байх ёстой гэв.

2004 оны 11 дүгээр сард АХБ-ны Захирагч нарын зөвлөлөөр тус банкны Ерөнхийлөгчөөр санал нэгтэй сонгогдсон ноён Курода энэ бүс нутгийн хэд хэдэн улс саяхны цунамигийн гамшгийн үр дагавартай тэмцэж буй энэ эгзэгтэй мөчид албан тушаалаа авч буйгаа хүлээн зөвшөөрч "Гамшигт нэрвэгдсэн улс орнуудад туслахын тулд АХБ чадах бүхнээ хийх болно" гэж цохон тэмдэглэжээ.

Шинэ ерөнхийлөгч ядуурлыг нийт бүс нутгийн хэмжээнд учирч буй хамгийн том бэрхшээл хэмээн онцлон авч үзсэн байна. Хөгжиж буй Азийн орнуудад ядуурал 1990 онд 34% байснаа 2002 онд 22% болж буурсан боловч энэ нь хэдхэн газраар хязгаарлагдаж байгаа юм.

Тэрээр Ази Номхон далайн улс орнууд өөр хоорондоо адилгүйтай адилхан тэдгээрийн хүрсэн ололт амжилт нь ч мөн харилцан адилгүй байгааг дурьдаад, Мянганы хөгжлийн зорилтууд нь ядуурлыг бууруулахад олсон ахиц дэвшлийг хэмжих гол хэмжүүр байх хэвээр байх болно. Гэхдээ эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхэд тухайн улс орны нөхцөл байдал, нэн тэргүүний зорилтыг харгалзан үзэх хэрэгтэй. Нийгмийн хамгийн эмзэг бүлгийнхэн эдийн засгийн өсөлтийн төлөөх өрсөлдөөн дунд мартагдан орхигдох учиргүй гэж хэлжээ.

"Ядуурлыг тогтвортой бууруулахад одоо болтол шийдвэрлэгдээгүй ирсэн хүүхэд, эмэгтэйчүүдийн асуудлуудад анхаарал тавьж хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх явдал зүй ёсоор тавигдаж байна. Тухайн улс орон бүр ямар арга замыг сонгох нь хамаагүй, гагцхүү Ази номхон далайн бүс нутаг Мянганы хөгжлийн бүх зорилтуудыг аль болох хурдан хугацаанд биелүүлэхийг чармайх ёстой" гэж тэрээр хэлсэн үгэндээ дурьджээ.

Тэрээр эдийн засгийн өсөлтийг хангах, ядуурлыг бууруулахад гадаадын шууд хөрөнгө оруулалт амин чухал болохыг тэмдэглээд, АХБ тус бүс нутагт бизнесийн эрүүл орчин бий болгоход хувь нэмрээ оруулна. Хувийн хэвшил, хөрөнгө оруулалтыг дэмжсэн төрийн бүтэц, бодлого явуулах зайлшгүй шаардлагатай хэмээв.

Дэд бүтцийг хөгжүүлэх нь эдийн засгийн өсөлтөд мөн чухал үүрэгтэй гэхдээ АХБ зэрэг байгууллагууд энэ үйл явцад байгаль орчны болон нийгмийн сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авснаар чухал үүрэг гүйцэтгэх учиртай. Санхүүжилт нь хувийн хэвшлээс гарсан ч бай төр энд чухал үүрэгтэй гэж Курода хэлсэн байна.

Ирээдүйд Азийн эдийн засгийн өсөлтийг хангахад энэ бүс нутгийн улс орнууд хоорондоо эвсэн нэгдэх үйл явцыг хөхүүлэн дэмжих явдал чухлаар тавигдах болно. Бүс нутгийг интеграцичлах ажил бүс нутгийн хөгжлийн банкны хувьд онцгой зорилт байх болно.

Харин АХБ өөрийнх нь хувьд гэвэл илүү үр ашигтай хөгжлийн байгууллага болох зорилт тавиад нэгэн эхэлсэн дотоод өөрчлөлт шинэчлэлтээ үргэлжлүүлэх аж. Тус банк үйлчлүүлэгчийнхээ зүг илүү чиглэсэн үйл ажиллагаа явуулах, гишүүн улс орнуудынхаа Засгийн газартай илүү нягт хамтран ажиллаж, дотоод журмаа түргэн шуурхай болгох хэрэгтэй байна гэж ноён Курода хэлэв.

Тэрээр би бүх хүч чадлаа АХБ-д зориулахаа амлаж байна гэж тус банкны ажилтнуудад хандаж хэлсэн үгийнхээ төгсгөлд дурьджээ.

* * * * *